

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 12 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт (өссөн дүнгээр)	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт удаашралтай байгаа шалтгаан	Хариуцах байгууллага	Нотлох баримт ирүүлсэн файлын нэр дугаар
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
9. ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ											
20	9.5. Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ.	9.5.4. Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.	2021-2025	0	4	85	85	1. Паркийн нэгж Монхимо ХХК нь одоогоор дүүргийн 50 иргэдийг ажлын байраар ханган үйлдвэрлэл эрхэлж байна. 2. Паркад нэгж үйлдвэр байгуулах ажлын хүрээнд 2025 онд дараах 4 байгууллагатай хамтын ажиллагааны санамж бичиг байгуулан төслийн техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулж холбогдох яамдаар баталгаажуулах ажил хийгдэж байна. 1. "Натур ларикс вүүд" ХХК-тай 2025.06.04-ний өдөр Санамж бичиг байгуулан хамтын ажиллагааг эхлүүлсэн. Тус үйлдвэр нь мод бэлтгэлийн үндсэн түүхий эдээс гадна үйлдвэрлэлийн хаягдал түүхий эд материалаар зиг-заг хавтан, модны үртсэн блок, тавилгын үйлдвэр зэрэг чиглэлээр цогц кластер үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой. 2. "Мах маркет" ХХК-тай 2025.06.04-ний өдөр Санамж бичиг байгуулан хамтын ажиллагааг эхлүүлсэн. Тус үйлдвэр нь малын махаар бүх төрлийн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд өдөрт 200 бод, 1000 бог төхөөрч, боловсруулах хүчин чадалтай экспортын чиглэлтэй үйлдвэр юм. Үйлдвэрлэлийн явцаас хаягдах дайвар түүхий эдэд тулгуурлан Паркийн хүнсний үйлдвэрлэлийн бүсэд дайвар боловсруулах, яс боловсруулах, малын тэжээл бэлтгэх, муур нохойн хоол үйлдвэрлэх зэрэг экспортын үйлдвэрүүдийг кластераар хөгжүүлэх зорилготой.	Паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан бөгөөд шинээр авахад шаардлагатай бодлогын баримт бичиг хараахан бүрдээгүй байгаа тул нэгж үйлдвэрүүдтэй санамж бичгийн хүрээнд хамтран ажиллаж байна. Тусгай зөвшөөрөл гарсны дараа Нэгжийн удирдлагатай нэгжээр байрших, газар ашиглах гэрээг тус тус байгуулан бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлж ажлын байрыг нэмэгдүүлэн ажиллах болно.	БНУТП	Хавсралт танилцуулга

Д/д	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
								3."Трее Треелинг ойл" ХХК-тай 2025.07.05-ны өдөр Санамж бичиг байгуулан хамтын ажиллагааг эхлүүлсэн. Тус үйлдвэр нь хүрэн нүүрснээс коксжуулсан нүүрс, синтетик газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүнд үйлдвэрлэлийн чиглэлийг хөгжүүлэх зорилготой. 4."Номин сүү" ХХК нь 2025.11.06-ны өдөр Санамж бичиг байгуулан хамтын ажиллагааг эхлүүлсэн. Тус үйлдвэр нь хоногт 6-7тн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах, 800 кг-1тн ааруул хийх хүчин чадалтай бөгөөд ааруул, цөцгий, шар тос зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэдэг ба Паркийн хүнсний үйлдвэрлэлийн бүсэд байршиж одоо байгаа хүчин чадлыг 60% нэмэгдүүлэх кластер үйлдвэр байгуулах зорилготой. Дээрх үйлдвэрүүд үйл ажиллагаагаа эхлүүлснээр 160 гаруй ажлын байр шинээр бий болно.			



ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ 2725050005 Б.БЯМБАЦЭЦЭГ

2025.12.02 /

ХЭРЭГЖИЛТ ТАЙЛАГНАСАН:

"БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК" ХК-ИЙН
ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА Б.Мичид-Эрдэнэ

2025.12.02 /

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2025 оны 12 дугаар сарын 02

Багануур дүүрэг

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

Хяналт-шинжилгээний зорилго нь Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2025 оны жилийн эцсийн хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ хийн удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, дараагийн шатны төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд чиглэл авахад оршино.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийхдээ Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтад баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, 6.4, 6.7 дахь хэсгүүдийг удирдлага болгов.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” ХК-тай хамааралтай 1 зорилт 1 арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжилтэд удирдлага болгож буй журмын дагуу хяналт-шинжилгээ хийхэд:


Бодлогын баримт бичгийн хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувиас дээш байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

“Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хугацаа дуусаж байгаа бодлогын баримт бичгийн ангилалд тооцож, журмын 6.4 дахь хэсэгт заасны дагуу хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувиас дээш байгаа учир үр дүнтэй гэж дүгнэлээ.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан “9.5.4. Дагуул хотуудад дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.” арга хэмжээ нь паркийн нэгж Монхимо ХХК нь дүүргийн 50 иргэдийг ажлын байраар ханган үйлдвэрлэл эрхэлж байна. Мөн шинээр 4 нэгж үйлдвэр санамж бичиг байгуулан 160 гаруй ажлын байрыг бий болгох зорилготой ажиллаж байна. Паркийн тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тул тусгай зөвшөөрөл авах ажлыг эрчимжүүлж 4 нэгж үйлдвэртэй гэрээ байгуулан бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн, ажлын байрыг шинээр бий болгон ажиллах нь зүйтэй байна.



ХЯНАСАН:

БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.БЯМБАЦЭЦЭГ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Н.ГАН-УНДРАХ